

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж, ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг зохиолын хэсгийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. /Даалгавар бүр 2 оноотой/

“Бууж мордох хорвоо”

Төгөөг орь залуу явахад Ангаа хэмээх нарийхан шар, ногоон дурдан ч юм уу бажгар өргөн гэгчийн бүс ороож, хошмогтой цагаан тоорцог чихийг нь сөхөн өмссөн ануухан өндөр хар хүн байлаа. Нүд булаахааргүй ч товхийсэн мөнгөн товчтой эмээл хазаар хэрэглэхийн дээр зун бол бэлгүй хэт зүүн, өвөл бол ясан савхтай үйсэн иштэй хутга бэл сэлттэй нь бүрэн зүүнэ.

Тэрбээр адуутай дайралдвал унага дааганаас нь аваад азарга морьдыг нь шинжиж байдаг зантай адуунд хайртай, сайн морь унах дуртай гялалзсан эр байлаа. Харсан үзсэн мал, дэл сул алдуул тааралдвал андахгүй, эрэл сурлын хүнд тус хүргэхийг нэр төрийн хэрэг мэт мөрдөн, ядарч зүдэрсэн хүнд тус дэм болохыг ариун үйл гэж баримтална. Харин морь малдаа ширүүн хүнд нүүр өгөх дургүй. Түүний эдэлж унасан морь нь хэзээд өнгөлөг, гундаж эцсэн явах нь нүдэнд үл өртөнө. Хартал талын салхи сөрөн дээлийнхээ сугыг хөөрөгдөн давхивал давхиж л явдаг, сольж юулж амжихгүй хэд хонож байвч тэгтлээ унаширч гундсан байх нь ховор. Тэгээд ч тэр үү нутгийн ихэс багагүй хүндэлнэ.

Далан долоо гараад хөөрхий, мориныхоо нуруунд гарч чадахгүй болсноо сая л нэг мэдэж, “Хүн өтөлнө гэдэг муухай юм аа... Унааныхаа нуруунд муу зовлогоо гаргаж чадахаа л больдог байна шүү... Зүүн өвдөгний нүдээр хатгуулаад хөлөө эмээлийн бүүрэг давуулчхаж чадахгүй боллоо. Ингээд унаа унах буян хийсээд өгдөг юм байна” гээд бүр гутарчихсан сууж байсан даа. Бид ер нь Ангаагийн насан дээр яаж шүү явах юм бол?...

/С.Дашдооров/

1. Ангаа морь малдаа ширүүн хүнд яагаад дургүй байдаг вэ?
 - A. Талын салхи сөрөн дээлийнхээ сугыг хөөрөгдөн давхивал давхиж л явдаг учраас
 - B. Харсан үзсэн мал, дэл сул алдуул тааралдвал анддаггүй учраас
 - C. Эрэл сурлын хүнд тус хүргэхийг нэр төрийн хэрэг мэт мөрддөг учраас
 - D. Ядарч зүдэрсэн хүнд тус дэм болохыг ариун үйл гэж баримталдаг учраас
 - E. Адуутай дайралдвал унага дааганаас нь аваад азарга морьдыг нь шинжиж байдаг зантай, адуу малд хайртай учраас
2. Эхийн тодруулсан цогцолбор утгын ямар зүйлчлэлд хамаарах вэ?
 - A. Хүний
 - B. Адгуусны
 - C. Хүний бүтээсэн
 - D. Сэтгэхүйн
 - E. Гараг эрхсийн
3. **“Тэгээд ч тэр үү нутгийн ихэс багагүй хүндэлнэ”** - онцолсон үг эхийн аль үйл явдалтай **холбогдохгүй** вэ?
 - A. Түүний эдэлж унасан морь нь хэзээд өнгөлөг.
 - B. Гундаж эцсэн явах нь нүдэнд үл өртөнө.
 - C. Зүүн өвдөгний нүдээр хатгуулаад хөлөө эмээлийн бүүрэг давуулчхаж чадахгүй боллоо.
 - D. Морь малдаа ширүүн хүнд нүүр өгөх дургүй.
 - E. Унасан морио сольж юулж амжихгүй хэд хонож байвч тэгтлээ унаширч гундсан байх нь ховор.
4. Дээрх эхийн сэдвийг илэрхийлсэн хэлцийг олоорой.
 - A. Эр хүн ядрахаар элгэн саднаа
 - B. Эрийг бүү бас
 - C. Залуудаа зовбол өтлөхдөө жаргана
 - D. Эрийг нас, уулыг цас
 - E. Хөгшин хүн хөглөвөл хөл гартаа гэмтэй
5. Эхийн гол санааг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.
 - A. Бид ер нь Ангаагийн насан дээр яаж шүү явах юм бол?...
 - B. Тэгээд ч тэр үү нутгийн ихэс багагүй хүндэлнэ.
 - C. Хүн өтөлнө гэдэг муухай юм аа...
 - D. Адуунд хайртай, сайн морь унах дуртай гялалзсан эр байлаа.
 - E. Түүний эдэлж унасан морь нь хэзээд өнгөлөг, гундаж эцсэн явах нь нүдэнд үл өртөнө.

6. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
A. Эргэцүүлэмж
B. Хүүрнэмж
C. Тайлбарламж
D. Тоочимж
E. Эргэцүүлэмж, хүүрнэмж хосолсон
7. “Ингээд унаа унах буян хийсээд өгдөг юм байна” - өгүүлбэрээс хоёр бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой.
A. Унаа унана. B. Буян хийснэ. C. Унаа хийснэ. D. Буян өгнө. E. Ингээд унана.
8. Утгын зүйлчлэл талаас бусдаасаа өвөрмөц өгүүлбэрийг олоорой.
A. Морь нь хэзээд өнгөлөг
B. Бүс ороож
C. Тоорцог өмссөн
D. Бэлгүй хэт зүүн
E. Эмээл хазаар хэрэглэх
9. Өрөвдөж хайрласан өнгө аястай хэсгийг олоорой.
A. ...эрэл сурлын хүнд тус хүргэхийг нэр төрийн хэрэг мэт мөрдөн
B. Бид ер нь Ангаагийн насан дээр яаж шүү явах юм бол?...
C. Хүн өтөлнө гэдэг муухай юм аа...
D. Далан долоо гараад хөөрхий, мориныхоо нуруунд гарч чадахгүй болсноо сая л нэг мэдэж
E. Унааныхаа нуруунд муу зовлогоо гаргаж чадахаа л больдог байна шүү...
10. “Хошмогтой цагаан тоорцог өмссөн” - өгүүлбэрийн өгүүлэхүүнийг захирах төлөвт хувиргасныг сонгоорой.
A. өмс B. өмссөн үү C. өмссөн дөө D. өмссөн шүү E. өмсөв
11. “Ядарч зүдэрсэн хүнд тус дэм болохыг ариун үйл гэж баримтална” - өгүүлбэрийг салаалан хувиргасан нь аль вэ?
A. Ядарч зүдэрсэн хүнд тус дэм болохыг ариун үйл гэж баримталдаг нь бахархууштай.
B. Зовж зүдэрсэн хүнд тус дэм болохыг ариун үйл хэмээн баримталдаг.
C. Ядарч зүдэрсэн хүнд тус дэм болдог.
D. Ариун үйл гэж баримталдаг зүйл нь ядарч зүдэрсэн хүнд тус дэм болох юм.
E. Хүнд тус дэм болохыг ариун үйл гэж баримтална.
12. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
A. Баруун толгодын ар шил дээрх гуулин цар шиг том улаан сар дээшлэн хөөрөх тусмаа жижгэрэн жижгэрсээр.
B. Уулын энгэр ташсан дардан шар замаар хоёр морьтой хүн зуузай холбон майхны нь чиглэн гэлдэрч яваа харагдав.
C. Эздэдээ сэтгүүлчдийн байгууллага нь шаардлага тавих ёстой асуудлууд ч маш их хуримтлагдсан байгаа.
D. Хялганы толгой явган салхинд уруудан бөхөлзөнө.
E. Найртай тансаг найман сарын эхэн үеэр баруунаас хүрэлцэн ирэх тууварчдын манлайд учралт хүн нь буух ёстой байлаа.
13. “Морь малдаа ширүүн хүнд нүүр өгөх дургүй” - өгүүлбэрийн нүүр өгөх дургүй байгаа шалтгааныг баталсан хэлц аль вэ?
A. Адуу бассан хүн амгайвчаар унана
B. Монгол хүн малаараа, монгол гэр үүдээрээ
C. Мориноос сайн унаагүй, тэмээнээс сайн хөсөггүй
D. Мал дагавал ам тосодно
E. Малаа зодвол үгүйрэхийн цондон
14. “Харсан үзсэн мал, дэл сул алдуул тааралдвал андахгүй, эрэл сурлын хүнд тус хүргэхийг нэр төрийн хэрэг мэт мөрдөн” - өгүүлбэрийн шууд бус тусагдахуун гишүүнийг олоорой.
A. хүнд B. мал C. алдуул D. эрэл сурлын E. хэрэг мэт
15. “Эрэл сурлын хүнд тус хүргэх” - гэдэгтэй ойролцоо санаат өгүүлбэрийг олоорой.
A. Ойрноос Должин аашны сайхныг үзүүлэх болж. Юу болсон юм бол доо.
B. Манай хүү чинь даруухан, ажилсаг, их зөөлөн чихтэй юм шүү дээ.
C. Эдэлж хэрэглэсэн, идэж уусан нь их болохоос биш хүнд тус болж гийгүүлсэн нь тун ховор санагдахуй анх удаа өөрийгөө чамлалаа.
D. Дашням түүнийг өрөвдөж, аль болохоор тус болохыг хичээдэг юм.
E. Гэвч хөөрхий өвгөнд түүний гарыг харахаас өөр арга байсангүй.

16. “Тэрбээр адуутай дайралдвал унага дааганаас нь аваад азарга морьдыг нь шинжиж байдаг зантай” – хэсэгт дүрсэлсэн Ангаагийн зан байдалтай дүйх хэсгийг олоорой.
- A. Даагагүй байтлаа унахыг хүснэ
B. Унан бүдрэх морь муухай, унтаад сэрэхгүй бэр муухай
C. Малчин хүн бэлчээр сонгодог, наймаачин хүн бэл боддог
D. Малд махан нүдтэй, хоолонд хоёр нүдтэй
E. Малч хүний нүд гярхай
17. “Ядарч зүдэрсэн хүнд тус дэм болох” - өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
- A. Нэрийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
B. Үйлийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
C. Цагийн байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
D. Холимог нийлмэл өгүүлбэр
E. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
18. “Хүн **өтөлнө гэдэг** муухай юм аа...” - онцолсон өгүүлэхүүнийг яаж хувиргавал байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр болох вэ?
- A. өтөлдөг B. өтлөх C. өтөлж D. өтлөхөөрөө E. өтөлсөн
19. “Ингээд унаа унах буян хийсээд өгдөг юм байна” гэсэн хэсэгт хөгширснийг нь унаа унах буян хийсэх хэмээн тойруулан дүрсэлсэн нь хэр оновчтой вэ?
- A. Бодитой зүйл л салхинд хийсдэг учраас буян хэмээх хийсвэр зүйлийг ингэж дүрсэлсэн нь оновчгүй болжээ.
B. Унаа унах болон буян нь хоорондоо утгын хувьд хамааралгүй учраас энэ дүрслэл тохиромжгүй.
C. Залуу насны аагаар адуу малд гарамгай байсан нь хөгшрөхийн эрхээр үгүй болсныг унааны буян хийснэ хэмээн дүрсэлсэн нь оновчтой болжээ.
D. Малын буян хийснэ гэж ярьдгаас унааны буян хийснэ гэдэггүй учир ингэж дүрслэх нь утгагүй.
E. Хөгшрөхийн хэрээр адуу малаасаа хөндийрч байгааг малын буян хийсэхгүй хэмээн тойруулан дүрсэлсэн нь оновчтой болсон.
20. Эс тусах, үүсмэл, өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх байдал, нэгэнт өнгөрсөн цагт нэрийн дагавартай үйл үгийг олоорой.
- A. өмссөн B. баримтална C. гундсан D. гутарчихсан E. зүдэрсэн
21. Бүгд гурван үе бүхий бүлэг үгийг олоорой.
- A. булаахааргүй, явахад, нарийхан, хошмогтой, ануухан
B. товхийсэн, адуутай, дайралдвал, дааганаас, азарга
C. гялалзсан, хэрэглэхийн, тааралдвал, андахгүй, хүргэхийг
D. зүдэрсэн, болохыг, баримтална, унасан, өнгөлөг
E. өртөнө, дээлийнхээ, давхивал, амжихгүй, гутарчихсан
22. “**Нүд булаахааргүй ч** товхийсэн мөнгөн товчтой эмээл хазаар хэрэглэх” - тодруулсан хэсгийг солин найруулбал аль нь тохиромжтой вэ?
- A. Нүд нээгдэхгүй ч B. Нүд хужирлахааргүй ч C. Нүд алдам ч
D. Нүд гүйцэхгүй ч E. Нүд үзүүрлэхгүй ч
23. “Далан долоо гараад **хөөрхий**, мориныхоо нуруунд гарч чадахгүй болсноо сая л нэг мэдэж...” - онцолсон баймжтай утга ойролцоо үгийг олоорой.
- A. үнэхээр B. зайлуул C. ёстой D. ерөөсөө E. зөвхөн
24. “...**Харин** морь малдаа ширүүн хүнд нүүр өгөх дургүй” - тодруулсан холбоосыг тохирох үгээр солин найруулаарай.
- A. Эсвэл B. Яагаад гэвэл C. Гэлээ ч D. Нөгөөтээгүүр E. Тэгээд
25. Эхийн өгүүлбэрүүдээс найруулгын дээд зэрэгт хувиргасныг олоорой.
- A. Сайн хүлэг унах дуртай. B. Нэр төрийн хэрэг мэт мөрдөн.
C. Унасан морь нь хэзээд өнгөлөг. D. Давхивал давхиж л явдаг.
E. Унааширч гундсан байх нь ховор.

26. “Морио сольж юулж амжихгүй хэд хонож байвч тэгтлээ унаширч гундсан байх нь ховор” - өгүүлбэрт **ороогүй** үгийн аймгийг олоорой.
 А. Орон цагийн нэр В. Жинхэнэ нэр С. Үйл үг D. Тооны нэр E. Тэмдэг нэр
27. Чөлөөт бус холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирохыг нөхөөрэй.
 Харсан үзсэн, шинжиж байдаг, эрэл сурал, давхиж явдаг, нэр төр, гарч чадахгүй,
 А. тус дэм В. хийсээд өгдөг С. нүд булаах D. ясан савх E. нүүр өгөх
28. “Энэ муу нүд чинь халуунд халдаггүй, хүйтэнд хөрдөггүй **бүлтгэр** шүү дээ”,
 “Эх нутгийн тэнгэр чи ээжийн **мэлмий** юм уу даа?” – өгүүлбэрүүдэд нүд хэмээх үгийг найруулгын зэргээр хувирган бичсэнийг хэрхэн дүгнэх вэ?
 А. Зарим үгсийн найруулгын доод зэргийг хүмүүс мэдэхгүй учир ингэж бичих нь тохиромжгүй.
 В. Зөвхөн сонин нийтлэлийн найруулгад хэрэглэдэг тул найруулгын алдаа болно.
 С. Доромж утгатай үгсээр утга шилжүүлэн дүрслэх нь тохиромжгүй.
 D. Судар номын эрхэмсэг дээд найруулгыг зарим хүн ойлгохгүй тул дунд найруулгаар бичих нь зөв.
 E. Үгийн өнгө аяс, өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг бүрэн илэрхийлэхэд дөхөмтэй учир найруулгын зэргээр бичсэн нь оновчтой.
29. “унаширч” гэдэг үгийн үйлээс нэр үг бүтээх дагаврыг олоорой.
 А. –аа В. –шир С. –ш D. –р E. –ааш
30. Эхээс сонгосон үгсээс бүтцээр нь зөв задалсныг олоорой.
 А. гял+лз+0+0+сан В. зов+лого+оо+0 С. давуул+0+чих+ж
 D. хэрэг+л+0+х+ийн E. барь+мт+л+на
31. Ямар нэгэн зүйлээс барих утгыг үүсгэсэн “-д” дагавартай бүлэг үгийг олоорой.
 А. Саваадах, ташуурдах, шавхуурдах, сүхдэх
 В. Уртдах, богинодох, нарийдах, томдох
 С. Хөгжимдөх, хуурдах, лимбэдэх, хуучирдах
 D. Чихдэх, сүүлдэх, хүзүүдэх, хөлдөх
 E. Хонгодох, цохдох, шанаадах, элэгдэх
32. “Тэдэнтэй чинь очиж уулзъя. Хорооных нь он шавыг тавьж, зааж зурж өгөхгүй бол хүүхдүүд хаа хамаагүй салхины аман дээр барьчихаж магадгүй” – өгүүлбэрүүдээс алдаатай бичсэн нэг үгийг зөв болгон зассаныг олоорой.
 А. барьчихаж В. уулзая С. тавиж D. салихны E. хороонийх
33. Бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн дагаврыг **найруулгын алдаатай** хэрэглэсэн жишээг олоорой.
 А. Ирэх хаврын шувуу эргэж, агь нүдлэх нас хүрэмгүй хол мэт санагдав.
 В. Дэндэв ах ширээ ат шиг бие жагссан сайхан залуу цэргээс халагдан ирж билээ.
 С. Бурхны хүч бидний мөхөс байдалд илүү алдаршигддаг.
 D. Морио амгайвчлан мордохоор олмоо чангалтал нэгэн бүсгүй хүн нуурын цаад хөвөөнөөс дуулах сонсогдов.
 E. Урт нүүдэлд аяншиж ядарсан хүн малын зоо амран, бие сэтгэлийн ган тайлагдав.
34. “Эр чадлаа багтааж ядсан амьтан **шиг**” - онцолсон баймж бүтээврийн утгатай хамгийн ойр хэсэг аль нь вэ?
 А. Үнээгээ түргэхэн **шиг** шувтарчхаад цаад бүсгүйдээ шөл хийж өг.
 В. Өвгөн ах минь яаж ийгээд эмнэлгийн бараа харах сан. Тэгэхгүй бол тэсэхгүй нь **шиг** байна.
 С. Урьд шөнө үерийн ус гучин алд л нэмэгдэх **шиг** боллоо.
 D. Үерийн усан дээр ув улаан тэргэл сар унаад ирсэн юм **шиг** тэр бүсгүйн царай зэс мэт улайн минчийсэн харагдав.
 E. Их тээлийн даваан дээр гаруут сэрүү татан сэтгэл уужрах ч **шиг** болж билээ.
35. Утга төгс өгүүлбэр бүтээхэд цэгийн оронд аль бүтээврүүд дарааллаараа тохирох вэ?
 “Хоёр нүд...ээ ертөнц... хар нулимс... бороон... дусал адил асгаруулна”
 А. –д, -ийг, -ыг, -ы В. –ээс, -ийн, -ыг, -ы С. –тэй, -ийн, -ыг, -ы
 D. –ээр, -өөс, -аа, -д E. –ийг, -ийн, -ыг, -ы

36. Зөв бичсэн хэсгийг олоорой.

- | | | | | |
|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|
| A | B | C | D | E |
| ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ |

37. Цэгийн оронд цагт нэрийн тохирох дагаврыг дарааллаар нь нөхөж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

- | | | | | |
|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|
| A | B | C | D | E |
| ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ | ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ
ᠮᠠᠨᠢᠨ ᠠᠨᠢ |

38. “Монголын нууц товчоо” зохиолд Чингис хаанд хандан:

“...Далан гурван хүлэгтэй
 Дархан өрлөг нөхөдтэй
 Далай Чингис чамдаа
 Дарагдаж мөхөв би чинь...” хэмээн хэн өгүүлсэн бэ?

- A. Чилэгэр бөх B. Таргудай C. Боорчи D. Жамуха E. Ван хан

39. “Монголын нууц товчоо” зохиолын:

“Ботго тормын борвийг хазах
 Өл буур мэт
 Бороот өдөр довтлон халдах
 Өлөн чоно мэт” - хэсэгт ямар дүрслэх хэрэглүүр илэрч байна вэ?

- A. Хүншүүлэл B. Тойруулал C. Ихэсгэсэн зүйрлэл
 D. Ёгтлол E. Төлөөлөл

40. Дараах зохиолуудын хэсгийг нэртэй нь зөв харгалзуулсныг сонгоорой.

- | | |
|--|---|
| 1. Таанын цагаан толгойноос өөр
Тайтгаруулах цэцэггүй нүцгэн тал минь | a. Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” жүжиг |
| 2. Хурмастын цагаан үүл
Хувилгаан цагаан үүл | b. Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс” тууж |
| 3. Эр хүн нөхөрлөхөд хад чулуу хайлж урсаж болдгийг,
эр хүн эвдрэхэд хан тэнгэр хагарч цуурч болдгийг
түмэн үе санатугай. | c. Б.Лхагвасүрэн “Боржигоны бор тал” шүлэг |
| 4. Сэтгэлийн амраг гэгч нь
Шижир алтнаас үнэтэй | d. Ц.Дамдинсүрэн “Зугаацахаар мордсон нь” найраглал |
| 5. Дамбыг мордоход Дэжид юу ч хэлсэнгүй. Дамба ч нүүр
өөд нь зүрхлэн харж чадсангүй. Хүү нь гэрийн хаяа
налан хойноос нь харсаар хоцорлоо. | e. Д.Намсрай “Жамухын өчил” өгүүллэг |

- A. 1c2d3e4b5a B. 1c2d3e4a5b C. 1a2d3c4e5b
 D. 1d2c3e4a5b E. 1b2e3d4a5c

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Аман зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|------------------------|
| a. Хүлгийг жолоогоор залдаг
Хүнийг ухаанаар залдаг | 1. Ардын дуу |
| b. Хур дэлтэй хул морь
Хурд ихтэй бор морь | 2. Онъсого |
| c. Хар хадны үнд халиун ягаан цэцэг ээ хө
Харанхуй шөнөөр боссон ээжийнхээ ачийг
яана вэ хө | 3. Зүйр цэцэн үг |
| d. Хамба торго хээгүй
Ханчин сувд нүхгүй | 4. Бэлгэ дэмбэрлийн үг |
| e. Хандгай буга харвах хүүтэй бол
Халиу булга эсгэх хүүхэнтэй бол | 5. Хэл зүгшрүүлэх үг |

2.2 Бууж мордох хорвоо” зохиолын хэсгээс авсан дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулаарай.

- | | |
|------------|---|
| a. Бажгар | 1. Нас хөгширсөн боловч бие тэнхлүүн сайн |
| b. Бэл | 2. Гадаргуу нь өөтэй, ширүүн дурдан |
| c. Юүлэх | 3. Юмны зах хормойгоор янзалж хөвөөлсөн эмжээрийн
дотуур нарийн хосолсон мөшгөөр |
| d. Ануухан | 4. Хэт хутга зэргийг зүүх оосрын чимэг |
| e. Хошмог | 5. Уналгын морь малыг сэлэх, солих |

2.3 Зөвийг нь олж харгалзуулаарай.

		1	2	3	4	5
a	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад зохих балархай эгшгийг өмнө нь бичдэг дүрмийг зөрчих үг	хурд	хурц	үндэс	товч	ногт
b	Зөөлрүүлэх үүргээр орсон “ь”-тэй үг	харья	хэлье	өгье	бичье	идье
c	Зөөлний тэмдэг “и” болохгүй үг	хань+л	зорь+лго	дохь+ж	тарь+х	ярь+ж
d	Эр үгэнд “-ы” бичих үг	хуурч	горхи	тагш	тулга	хориг
e	Үйлийн болзох тийн ялгалын “-бал ⁴ ” нөхцөлөөр хувилах үг	тоол-	таар-	наад-	хийс-	дайж-

2.4 Хэрэглээний бичвэрийг жишээтэй нь харгалзуулаарай.

- | | |
|---|---------------------|
| a. нь БЗД-ийн-р хороонд оршин суудаг нь үнэн болно. | 1. Өргөдөл |
| b. Б.Ринчений уран бүтээлийн оргил нь “Үүрийн туяа” гурамсан роман юм. | 2. Танилцуулга |
| c. ... оноо тэнцсэн тул миний хүсэлтийг харгалзан, сургуульдаа элсүүлэн суралцуулна уу? | 3. Тодорхойлолт |
| d. Аав минь холч ухаантай, голч үгтэй нэгэн байсан. | 4. Өдрийн тэмдэглэл |
| e. Их далайн зүг аяны жолоо залсан дурсамжит өдрүүд сэтгэлд уяатай... | 5. Дурсамж |

2013 оны 7 сарын17

